

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар
Сарын 12-ны өдрийн 505 дугаар тогтоолын хавсралт

“ХӨХ ГАН” ХК-ИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

“Хөх Ган” Хувьцаат Компани

Хаяг: Хан уул 1-р хороо Чингэсийн өргөн чөлөө 50-р байр 15 давхар

Утас: 70072777

Факс: 70071777

Электрон хаяг: www.khuhgan.mn

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 9010001075

Регистрын дугаар: 5126142

Үйл ажиллагааны чиглэл: төмрийн үйлдвэр

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 936

3. Үнэт цаас гаргагчийн түүх, тухай зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Хөх ган ХК нь 2007 онд Эрдэнэт хотод байгуулагдсан бөгөөд 2008 онд хувьцаат компани болж өргөжин одоогийн байдлаар 300 гаруй хувьцаа эзэмшигчтэй болсон. Тус үйлдвэр нь 2009 оны 10 сард ашиглалтанд орсон ба жилдээ 40000 тн төмрийн хүдрийн баяжмалыг шууд ангижруулах технологиор боловсруулж, үйлдвэрийн 2-р шугам нь 30000 тн 92-98%- ийн агуулгатай шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэх хүчин чадалтай.

Шууд ангижруулах технологи нь хамгийн сүүлийн үеийн шинэ технологи бөгөөд энэхүү үйлдвэр нь Монгол улсын энэ чиглэлийн анхдагч үйлдвэр юм. Тус компанийн үйлдвэрлэдэг шууд ангижруулсан төмөр нь хаягдал төмөр, ширмийг бүрэн орлох чадвартай, сайн чанартай гангийн түүхий эд юм.

4. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Бэрэн Групп ХХК		52.53%
2	Firebird GM 2 S.A.R.L		10.42%
3	БиДиСЕК ҮЦК ХК		15.02%
4	Д.Эрдэнэчимэг		7.13%

5. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Ц.Батболд	Гүйцэтгэх захирал	Дээд	Бэрэн Групп ХХК
2	Б.Мөнхтөр	ТУЗ-ийн дарга	Дээд	Бэрэн Групп ХХК
3	Ц.Батбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Бэрэн Групп ХХК
4	Д.Давгадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Таван Толгой Транс ХХК
5	Д.Энхбат	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Өнөд дэвжих транс ХХК
6	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСЕК ҮЦК ХК тэргүүн дэд захирал
7	Г.Өлзий	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Бэрэн лэнд девелопмент ХХК
8	Н.Цэцэгдэмбэрэл	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Бэрэн Групп ХХК
9	Б.Мянганбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	СиБиЭм ХХК

6. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Бэрэн Групп ХХК		52.53%
2	Firebird GM 2 S.A.R.L		10.42%
3	БиДиСЕК ҮЦК ХК		15.02%
4	Д.Эрдэнэчимэг		7.13%

II. ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компанийн 2012, 2013, 2014 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
Борлуулалт	413.9	162.4	1,771.6
Борлуулалтын хөнгөлөлт			
Цэвэр борлуулалт	413.9	162.4	1,771.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	311.7	166.3	1,830.7
Нийт ашиг	102.2	-3.6	-0.059
Үйл ажиллагааны зардал	221.4	333.6	739.1
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	0.573	-0.017	0.0018
Үйл ажиллагааны бус зардал			
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	-133.1	-323.6	-825.8
Орлогын татварын зардал	-	-	-
Цэвэр ашиг /алдагдал/	-133.1	-323.6	-825.8

Компанийн 2012, 2013, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он
Эргэлтийн хөрөнгө	4,597.6	4,542.3	4,632.9
Эргэлтийн бус хөрөнгө	11,663.2	14,733.5	15,423.9
Нийт хөрөнгийн дүн	16,260.9	19,275.8	20,056.9
Богино хугацаат өр төлбөр	8,322.2	8,660.7	11,017.6
Урт хугацаат өр төлбөр		3,000.0	2,250.0
Эзэмшигчдийн өмчийн дүн	7,938.7	7,615.1	6,789.3
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	16,260.9	19,275.8	20,056.9

2. Компани нь 2014 оны жилийн эцсийн байдлаар -3,398.6 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай байгаа ба өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.

3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл:

№	Овог нэр	Цалин урамшуулалын хэмжээ	Хандив тусламжийн хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Ц.Батболд	1,440,000	-	-	-
2	Б.Мөнхтөр	1,800,000	-	-	-
3	Ц.Батбаяр	1,440,000	-	-	-
4	Д.Давгадорж	1,440,000	-	-	-
5	Д.Энхбат	1,440,000	-	-	-
6	Б.Лхагвадорж	1,440,000	-	-	-
7	Г.Өлзий	1,440,000	-	-	-
8	Н.Цэцэгдэмбэрэл	1,440,000	-	-	-
9	Б.Мянганбаяр	1,440,000	-	-	-

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

Компанийн хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд алдагдалтай ажиллаж байгаагаас шалтгаалан одоогоор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараагаагүй болно.

5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“Хөх Ган” ХК нь 2014 онд “Компанийн тухай хууль”-ийн 87, 89 дгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил боловсрол	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1	Ц.Батболд	Хөх Ган ХК гүйцэтгэх захирал	Бизнесийн удирдлага	-	Хараат
2	Б.Мөнхтөр	Бэрэн Групп ХХК ерөнхий захирал	Цөмийн физикч	-	Хараат
3	Ц.Батбаяр	Бэрэн Групп ХХК гүйцэтгэх захирал	Инженер	-	Хараат
4	Д.Давгадорж	Таван Толгой транс	Инженер	-	Хараат

		ХХК ерөнхий захирал			
5	Д.Энхбат	Өнөддэвжих building ХХК ерөнхий захирал	Механик	-	Хараат бус
6	Б.Лхагвадорж	БиДиСЕК ҮЦК ХК тэргүүн дэд захирал	Нефтийн инженер	-	Хараат
7	Г.Өлзий	Бэрэн лэнд девелопмент ХХК менежер	Санхүүгийн удирдлага	-	Хараат бус
8	Н.Цэцэгдэмбэрэл	Бэрэн Групп ХХК эдийн засагч	Бизнесийн санхүүч	-	Хараат бус
9	Б.Мянганбаяр	СиБиЭм ХХК эдийн засагч	Санхүүгийн менежмент	-	Хараат

Компани нь 2014 оны 04-р сарын 28-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2014 оны 05-р сарын 20-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон:

- a. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Н.Цэцэгдэмбэрэл, Д.Энхбат, Б.Лхагвадорж гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Цэцэгдэмбэрэл-г томилсон.
- b. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Ц.Батбод, Н.Цэцэгдэмбэрэл, Г.Өлзий гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ц.Батболд-г томилсон.
- c. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Б.Мөнхтөр, Г.Өлзий, Н.Цэцэгдэмбэрэл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Мөнхтөр-г томилсон.

2014 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 4 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 6 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 2 тогтоол, 2 тэмдэглэл гарган баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан.

Тайлангийн хугацаанд “Нэр дэвшүүлэх хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал, “Аудитын хороо” 2 удаа хуралдаж 4 асуудал, “Цалин урамшуулалын хороо” 2 удаа хуралдаж 2 асуудал тус тус хэлэлцсэн байна. ТУЗ-ийн хурлын дундаж ирц 77.9 % байсан.

ТУЗ-с гаргасан тогтоол, шийдвэр түүний биелэлтийг өөрийн компанийн цахим сайтуудаар цахим хэлбэрээр явуулж тайлагнаж ажилласан.

7. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:

Манай компани нь 2008 онд хувьцаат компани болж одоогийн байдлаар 900 гаруй хувьцаа эзэмшигтэй болсон. Тус үйлдвэр нь жилдээ 40,000 тн төмрийн хүдрийн баяжмалыг шууд ангижруулах технологиор боловсоруулж 92-98%-н агуулгатай шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэж байна. Тус үйлдвэр нь 2014 онд 140 гаруй ажилчидтайгаар үйлдвэрлэлт явуулсан жилийн хагаст нь үйлдвэрлэлт явуулсан үндсэндээ агломерат үйлдвэрлэх боломжтой гэдгийг баталгаажуулсан. Үйлдвэрлэлтийн өртөгт нөлөөлөх гол түүхий эд болох баяжмалын үнийн өсөлт нь сар бүрээр өсөж байсан боловч бид эсрэгээрээ үйлдвэрлэлтийн хүчин чадал болон зөв зохион байгуулалтийн хүчинд өртөг маань өсөлтгүй харин бууралттайгаар явсан билээ. 2014 оны сүүлээр кокс үйлдвэрлэх туршалтыг явуулж эхэлсэн байгаа. Үйлдвэрлэлээс гадна бид ажилчидтайгаа хамтран тэмцээн уралдаан зохион байгуулж ажилсан билээ. Санхүүгийн тодорхой шалтгааны улмаас бид 2014 оны өдрийн үйлдвэрлэлтийг бага хэмжээд явуулсан харин 2015 оноос бид хүчин чадлаа бүрэн ашиглан ажиллах зорилготой байгаа. 2014 оноос бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээ 35%-р нэмэгдүүлж борлуултын орлого 1.7 тэрбумын борлуулалт хийсэн энэ нь өмнөх оноос 91%-р өссөн үзүүлэлттэй байгаа.

III. ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компани нь 2014 оны 04 сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
- b. Аудитын хорооны тайлан дүгнэлт
- c. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв
- d. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

e. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх

Компани нь 2013 оны 04 сарын 24-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлуудыг шийдвэрлсэн.

- a. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b. 2012 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан
- c. 2013 компанийн бизнес үйл ажиллагааны төлөвлөгөө
- d. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тоог өөрчлөх тухай /Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах/
- e. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- f. ТУЗ-н зардал батлах
- g. Бусад зэрэг асуудлуудыг тус тус хэлэлцэн баталж холбогдох тогтоол шийдвэрүүдийг гаргаж эрх бүхий байгууллагууд болох СЗХ болон МХБ ТӨХК-д холбогдох материалуудыг цаг тухай бүрт хүргэн өгч ажилласан.